



## ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 12/10

Дадал сум

Г Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэхь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/622 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт мал, тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллогын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд зохион явуулсугай.

2. Мал тэжээвэр амьтан, хашаа, худгийн 2024 оны жилийн тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

### Ажлын хэсгийн

ахлагч Нарийн бичгийн	М.Ариунгэрэл	(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
дарга Гишүүд	Д.Сүнжидмаа Э.Баасанхүү А.Азжаргал Г.Ган-Эрдэнэ А.Анар	(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн) (Баян-Овоо багийн Засаг дарга) (Онон багийн Засаг дарга) (Агац багийн Засаг дарга) (Балж багийн Засаг даргыг түр орлон гүйцэтгэгч)
	Ч.Бат-Эрдэнэ С.Мөнх-Эрдэнэ Д.Батзориг	(Хөдөө аж ахуйн тасгийн дарга) (Мал эмнэлгийн тасгийн дарга) (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

3. Жилийн эцсийн мал тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллогод зарцуулах 1,339,680 (Нэг сая гурван зуун гучин есөн мянга зургаан зуун наян) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т зөвшөөрсүгэй.

010000559